



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/782

Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор энэ тушаалын хавсралтад заасан Эрүүл мэндийн сайдын тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Төрөөс баримтлах бодлого, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг бусад бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусган хэрэгжүүлэхийг газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хүчингүй болсон Төрөөс баримтлах бодлого, Үндэсний хөтөлбөрийн 2021 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хугацаанд нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ц.Эрдэмбилэг)-д даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141213415

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар
сарын 18-ний өдрийн А/78 дугаар
тушаалын хавсралт



Хүчингүй болсонд тооцох тухай Эрүүл мэндийн сайдын
тушаалын жагсаалт

Нэр. Төрөөс баримтлах бодлого:

1. “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг 2020-2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/103 дугаар тушаал.

Хоёр. Үндэсний хөтөлбөр, хөтөлбөр:

2. “Үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/128 дугаар тушаал;

3. “Төлөвлөгөө батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/358 дугаар тушаал;

4. “Төлөвлөгөө батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/72 дугаар тушаал;

5. “Төлөвлөгөө батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/167 дугаар тушаал;

6. “Төлөвлөгөө батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/163 дугаар тушаал;

7. “Төлөвлөгөө батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/413 дугаар тушаал.